

МОНГОЛ - ПОЛЬШИЙН ХАРИЛЦАА - 55 ЖИЛД

*Ж.Алтангэрэл**

Монгол Улс, Польш Улсын хооронд 1950 оны 4 дүгээр сарын 14-нд элчин сайдын яамны хэмжээнд дипломат харилцаа тогтоосон бөгөөд манай тал 1959 онд Варшавт, Польшийн тал 1960 онд Улаанбаатарт байнгын Элчин сайдын яамаа тус тус нээн ажиллуулжээ. 1959 оныг хүртэл Москва дахь манай улсын Элчин сайдын яам БНПАУ-д, 1960 оныг хүртэл Бээжин дэх БНПАУ-ын Элчин сайдын яам манай улсад тус тус хавсран сууж байжээ.

Польшийн тал өөрийн орны эдийн засгийн бэрхшээлтэй байдлаас шалтгаалан 1995 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн Улаанбаатар дахь Элчин сайдын яамны үйл ажиллагаагаа зогсоосон байсан бөгөөд 1999 онд сэргээх шийдвэр гаргаж, 2000 оны 8 дугаар сараас БНПУ-ын Элчин сайдын яам Монгол Улсад үйл ажиллагаагаа сэргээгээд байна. БНПУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кшиштоф Дэмбницки 2001 оны 5 дугаар сарын 30-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойшхи хагас зуу гаруй жилийн хугацаанд ялангуяа хоёр орны харилцаа улс төрийн салбарт тасралтгүй явагдаж ирсэнийг дараах айлчлалууд гэрчилж байна. Тухайлбал:

Өндөр дээд хэмжээний айлчлал: 1962 онд БНПАУ-ын нам-засгийн төлөөлөгчид Монголд, 1964 онд БНМАУ-ын нам – засгийн төлөөлөгчид Польшид, 1968 онд БНПАУ-ын Төрийн Зөвлөлийн дарга М.Спыхальски Монголд, 1970 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу Польшид, 1975 онд БНПАУ-ын Төрийн Зөвлөлийн дарга Г.Яблоньски Монголд, 1986 онд БНПАУ-ын Ерөнхийлөгч В.Ярузельски Монголд, 1988 онд МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга бөгөөд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх Польшид, 1999 онд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди Польшид;

Парламентын тэргүүн нарын айлчлал: 1984 онд БНПАУ-ын Сеймийн маршал С.Гуцва, 1991 онд Польшийн Сенатын дэд маршал З.Курадовска, 1995 онд Польшийн Сенатын маршал А.Стружик нар Монголд, 1997 онд Монгол Улсын Их Хурлын дарга Р.Гончигдорж Польшид;

*Ж.Алтангэрэл - ахмад дипломатч

Гадаад хэргийн сайд нарын айлчлал: 1972 болон 1984 онд БНПАУ-ын ГЯЯ-ны сайд С.Ольшовски, 1987 онд БНПАУ-ын ГЯЯ-ны сайд М.Ожеховски, 2004 онд БНПУ-ын ГЯЯ-ны сайд В.Чимошевич нар Монголд, 1974 онд БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Л.Ринчин, 1978 онд БНМАУ-ын ГЯЯ-ны сайд М.Дүгэрсүрэн нар Польшид тус тус айлчилсны зэрэгцээ хоёр улсын ЕТГ, парламентын хооронд болон ажил төрлийн холбоо бүхий яамд, байгууллагуудын хооронд төлөөлөгчид тогтмол солилцож иржээ.

БНМАУ, БНПАУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээг анх 1975 онд Улаанбаатар хотноо байгуулсан бөгөөд энэхүү гэрээний үзэл санааны дагуу хоёр орны хоорондын улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа 1980-аад оны дунд үе хүртэл идэвхтэй явагдаж ирсэн.

БНМАУ-ын Засгийн газар, БНПАУ-ын Засгийн газрын хооронд анхны худалдааны хэлэлцээр 1957 онд, анхны соёлын хэлэлцээр 1958 онд тус тус байгуулагджээ. Мөн БНПАУ-аас манай улсад 1961-1965 онд эдийн засгийн тусламж үзүүлэх тухай анхны хэлэлцээр 1961 оны 7 дугаар сарын 13-нд байгуулагджээ.

Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол-Польшийн Засгийн газар хоорондын Комисс анх 1972 онд байгуулагдсан бөгөөд ийнхүү комисс байгуулагдсан явдал нь хоёр орны хооронд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

БНПАУ-ын техникийн тусалцаатайгаар Улаанбаатар хотод мод боловсруулах комбинат, хөнгөн бетон завод, спиртийн үйлдвэр, халиман цавууны үйлдвэр, ноосны үйлдвэрийн нэгдлийн эрдэм шинжилгээ - туршилтын төв, Дархан хотод царууц тоосго, шохойн үйлдвэр, Хархорин хотод спиртийн үйлдвэр тус тус баригдан ашиглалтад орж, эдгээр үйлдвэр төслийн хүч чадлаа хугацаанд нь эзэмшсэн явдал манай улсын улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөт зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Манай тал БНПАУ-тай мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тухайлбал малын хээл хаялт, сувайралттай тэмцэх, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн ургамлын өвчин, хортонтой тэмцэх талаар амжилттай хамтран ажиллаж байсан бөгөөд БНПАУ мал эмнэлгийн 14 лаборатори, оношлох 90 кабинетийг иж бүрэн төхөөрөмжөөр тоноглож өгсний зэрэгцээ олон арван мэргэжилтнээ томилон ажиллуулж байв.

Ийнхүү хамтын ажиллагааны олон арван үйлдвэрүүд баригдаж, арга хэмжээнүүд хэрэгжсэн нь манай орны барилгын материалын болон модон эдлэлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйг цаашид хөгжүүлэх, манай улсын экспортын нөөц бололцоог нэмэгдүүлэхэд тус дөхөм болсон байна.

БНПАУ олон талын хэлэлцээрийн үндсэн дээр Улаанбаатар хотын “Универсам”-ыг барих, Олон улсын геологийн экспедицийн үйл ажиллагаанд оролцох, эрдэм шинжилгээний төв лабораторид тоног төхөөрөмж нийлүүлэхэд өөрийн хувь хөрөнгийг гаргах замаар буцалтгүй тусламж үзүүлэв.

Түүнчлэн БНПАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр манай олон арван оюутан, аспирантыг Польшийн их дээд сургуулиудад хүлээн авч сургах, монгол иргэдийг үйлдвэрлэлийн дадлага хийлгэж мэргэжлийг нь дээшлүүлэх, Монголд ажиллах польшийн мэргэжилтнүүдийн зардлын хэсгийг нөхөх зэрэг арга хэмжээ хэрэгжиж байв.

Польш Улс 1990 он хүртэлх хугацаанд өөрийн улсын засгийн газрын тэтгэлгээр манай улсын улс ардын аж ахуйд хэрэгцээтэй төрөл бүрийн мэргэжлээр 200 гаруй боловсон хүчнийг бэлтгэж өгсөн бөгөөд одоо ч гэсэн жил бүр 10 оюутныг хүлээн авч сургасаар байгаа болно.

1980 оны дунд үе хүртэл хоёр орны бараа гүйлгээний хэмжээ өсч, улмаар бүтэц нь улам боловсронгуй болж байв. Манай улс Польшид хонины угаасан ноос, тэмээний ноос, өлөн гэдэс, малын арьс, тарвага зурамны арьс, үхрийн мах зэргээс гадна сүлжмэл эдлэл, гоёл чимэглэлийн зүйл, хагас үнэт чулуу зэрэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гаргаж, Польшоос орчин үеийн машин тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгсэл, цахилгаан техникийн бараа, АН-2 нисэх онгоц, морин хадуур зэрэг үйлдвэрлэл-техникийн зориулалттай барааг худалдан авч байв. БНПАУ манай экспортод гаргаж байгаа зарим нэр төрлийн бүтээгдэхүүнд урамшлын үнэ тогтоож байв.

1960 оноос эхлэн манай хоёр орны геологийн салбар дахь хамтын ажиллагаа хөгжиж ирсэн бөгөөд польшийн геологчид 1962-1964 онд Ховд, Увс, Говь-Алтай аймгийн нутагт, 1979 онд төвийн районд геологи хайгуулын ажлыг явуулж, ашигт малтмалын хэд хэдэн ордыг илрүүлэв.

БНПАУ нь Монгол дахь Олон улсын геологийн экспедицийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, улмаар уг экспедицийг бэхжүүлэхэд зориулан тоног төхөөрөмж нийлүүлж, мэргэжилтнээ томилон ажиллуулж байв. Польшийн мэргэжилтнүүдийн оролцоотой уг экспедицийн

геологийн анги 1976-1977 онд хойд Хэрлэнгийн район, 1978-1980 онд Тугалтайн нуруу, Зүлэгт, Заанширээ, 1981-1983 онд Говийн өмнөд район, Сайхандулаан, Цагаан давааны бүс нутагт эрэл зураглалын ажлыг явуулав.

Геологи хайгуулын салбарт хамтран ажиллах асуудлаар хоёр улсын засгийн газрын хооронд 1981-1985 онуудад байгуулсан хэлэлцээрүүдийн дүнд Монгол-Польшийн геологийн хамтарсан экспедиц 1984 онд байгуулагдаж, Лугийн голын районд геологийн хамтарсан хайгуулын ажлыг явуулж, 20 гаруй хүдрийн биетийг илрүүлжээ.

Манай хоёр хоорондын шинжлэх ухаан-техникийн салбар дахь хамтын ажиллагаа 1961 оноос эхэлсэн юм. Энэ хамтын ажиллагаа нь манай үндэсний боловсон хүчин бэлтгэх, улс ардын аж ахуйд орчин үеийн өндөр бүтээмжтэй техник, технологийг нэвтрүүлэх, мэргэжилтэн солилцох, сонирхсон сэдвээр хамтын судалгаа явуулах, зарим бүтээгдэхүүний загвар солилцох зэрэгт чиглэгдэж байв.

Ардчилсан үйл явц Польшид 1980-аад оноос, Монголд 1990-ээд оноос идэвхтэй өрнөж, улмаар манай хоёр орон зах зээлийн эдийн засагт шилжсэн явдал хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг шинэ зарчимд нийцүүлэн хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай тулгарсан юм.

Ийнхүү хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа шинэ зарчимд тулгуурлан хөгжих болсонтой уялдан Монгол, Польшийн хооронд байгуулсан бүх гэрээ, хэлэлцээрийг цэгцлэх шаардлага гарч ирсэн. Энэ нь хоёр орны харилцааны тулгуур баримт бичгийн заалтууд харилцааг хөгжүүлэх өнөөгийн бодит шаардлагад нийцэхгүй болсонтой холбоотой бөгөөд энэ үүднээс “Монгол, Польшийн хооронд 1954-1994 онд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн үйлчлэлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 1995 оны 11 дүгээр сард Варшав хотноо байгуулсан юм.

Хоёр орны хооронд байгуулсан “Найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээ” болон “Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг 2000 он хүртэл хөгжүүлэх тухай Программ”-ыг тус тус 1993 онд, “Иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр”-ийг 2000 онд цуцалсан. Мөн Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол-Польшийн Засгийн газар хоорондын Комисс 1989 онд үйл ажиллагаагаа зогсоов.

Монгол, Польшийн шинэ үеийн харилцааны эрх зүйн үндсийг бүрэлдүүлэх ажил хийгдсээр байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд хоёр талын хооронд “Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах

тухай хэлэлцээр”, “Орлогын ба хөрөнгийн татварыг давхардуулан олгохгүй байх тухай хэлэлцээр”, “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээр”, “Хоёр орны иргэдэд эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх тухай хэлэлцээр”, “Соёл, боловсролын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Шинжлэх ухаан-технологийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” тус тус байгуулагдаад байна.

Боловсрол, эрдмийн зэргийн үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх, мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай асуудлаар тус тус хэлэлцээр байгуулахаар хоёр тал ярилцаж байгаа болно.

Одоо манай хоёр улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрууд, Боловсролын Яамд, Шинжлэх ухааны Академиуд шууд хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Монгол оронд ардчиллыг хөгжүүлэхэд Польшийн тал байнга тусласаар ирснийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Монголд БНПУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн 6 нэгж барилга, худалдаа, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. 2000 онд Польшоос Монголд 1,6 сая ам.долларын хөрөнгө оруулжээ.

Худалдааг таван жилээр төлөвлөдөг байсан үед хоёр орны худалдааны нийт эргэлт 100 гаруй сая шилжих рубльд хүрч байсан бол 2003 онд 6,5 сая ам.доллар болж буурчээ. Худалдааны энэхүү эргэлтэд манай импорт 90 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд Польшоос ихэвчлэн хүнсний болон өргөн хэрэгцээний бараа, барилгын материал оруулж ирж байна.

Сүүлийн жилүүдэд Монголд болсон зудын гамшигтай тэмцэхэд зориулж БНПУ-ын Засгийн газар 20 мянган ам.долларын тусламж үзүүлэх тухай шийдвэр гаргаж хүнсний бүтээгдэхүүн ирүүлсний зэрэгцээ 2001 онд 10 мянган ам.долларын тусламж үзүүлжээ. Мөн Польш-Монголын найрамдлын нийгэмлэг 5 мянган ам.долларын үнэ бүхий 500 кг эм тусламж болгон ирүүлжээ.

Одоо манай 2000 орчим иргэн Польшид түр оршин сууж, худалдаа наймаа эрхэлж, ардын эмнэлгийн чиглэлээр ажиллаж байна. Польшид манай иргэд дангаар буюу польшийн иргэдтэй хамтарч 30 гаруй жижиг пүүс ардын уламжлалт эмнэлгийн чиглэлээр ажиллуулж байна.